



Г СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА Г.ГАНТӨМӨР ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019 01.17 № 057/447.  
танай 2018.12.31 ны № 01/1189-Т

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай Г

Стандарт, хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газрын ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Даадуугийн Болормаа, Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Сүхбаатарын Соронзонболд, Намжилын Батжаргал, Хэмжил зүйн хүрээлэнгийн ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Баасанжавын Байгалмаа нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Д.Болормаа нь хүнсний дэлгүүр, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Ё Эс Би" ХХК, "Сийлэн-Од" ХХК-иудын гүйцэтгэх захирлаар тус тус бүртгэлтэй байх тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмыг баримталж ажиллах нь зүйтэй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

*Xaashbaatar*

Х.ХАШБААТАР



*Хангай*



0000648